# БУЛГАН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

# САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Булган аймгийн Тэшиг сумын Ерөнхий боловсролын сургууль 2025 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн аудитын тайлан

**Аудитын код: БУА-2026/141/НА-СТА-ТШ3**


| | |
|---|---|
| Цахим хуудас: www.audit.mn<br>Булган аймаг<br>2026 он | Булган аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор: Д.Батцогт<br>Утас 70342580 Цахим хаяг: Battsogtd@audit.gov.mn<br><br>Булган аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, аудитын менежер: Ж.Энхцоодол<br>Утас: 70342716 Цахим хаяг: enkhtsoodolj@audit.gov.mn<br><br>“Бэйкер Тилли Далайван Аудит” ХХК-ийн Орхон аймаг дахь салбарын захирал:Д.Мягмарсүрэн<br>Утас: 99030170 Цахим хаяг: dalaivan.et@gmail.com<br><br>“Бэйкер Тилли Далайван Аудит” ХХК-ийн Орхон аймаг дахь салбарын Аудитор: Б.Пүрэвсүрэн<br>Утас: 99921600 Цахим хаяг: dalaivan.orkhon@gmail.com |


Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

**АГУУЛГА**


1. Хараат бус аудиторын дүгнэлт ........................................................................................
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл ........................................................
3. Санхүүгийн тайлангийн тодруулга............................................................................................
   3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа....................................................................................
   3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин ..................................................................................
   3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал..........................................................................
   3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлт .......................
4. Аудитын тайлан ...........................................................................................................................
   4.1 Ерөнхий зүйл ..........................................................................................................................
   4.2 Материаллаг байдал ..............................................................................................................
   4.3 Төрийн хэмнэлтийн хуулийн хэрэгжилт...............................................................................
   4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал .........................
   4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт ..................................................
   4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал ...............................................................................
5. Аудитын илрүүлэлт ....................................................................................................................
6. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл ....................................................................


**Товчилсон үгийн жагсаалт**

| | |
|---|---|
| УСНББОУС | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт |
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |
| ТӨБЗГ | Төрийн Өмчийн Бодлого Зохицуулалтын Газар |
| ЗДТГ | Засаг Даргын Тамгын Газар |

БУЛГАН АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Анхдагчдын өргөн чөлөө 1-120,
Жаргалант, 5-р баг, Булган сум, Булган аймаг,
63082, Утас/Факс:7034-2580
Цахим шуудан:bulgan@audit.gov.mn

2026.02.24. № 226.

танай______________ны №______________т

ТЭШИГ СУМЫН ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛИЙН ЗАХИРАЛ Д.ЭНХТӨР ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Тэшиг сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Тэшиг сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Асуудлыг онцолсон хэсэг**

Тэшиг сумын Ерөнхий боловсролын сургууль нь 2025 онд 23 бүлэгт 600 хүүхэдтэй үйл ажиллагаа явуулан гүйцэтгэлээр санхүүжсэн. Тайлант онд Боловсролын яамнаас 82,960.0 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө, Булган аймгийн Тэшиг сумын орон нутгийн хөгжлийн сангаас 69,750.0 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг үнэ төлбөргүй хөрөнгөөр бүртгэн санхүүгийн тайланд тусгасан байна.

**Аудитын гол асуудал**

Засгийн газрын 2024 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн 238 дугаар тогтоолоор "Цалин хөлс шинэчлэн батлах тухай" төрийн албан хаагчдын цалин хөлсийг шинэчлэн тогтоосон байна.

Боловсролын ерөнхий газрын 2025 оны 01 сарын 23-ны 1/383 албан тоотоор 2024-2025 оны хичээлийн жилд сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэх хэвийн үйл ажиллагааг хангахтай холбоотойгоор 2025 оны батлагдсан төсвийг зориулалтын дагуу үр ашигтай зарцуулах, төсвийн хөрөнгийн ашиглалтын үр дүнг сайжруулах, зөв зохистой удирдах, өр, авлага үүсгэхгүй байх зарчмыг баримтлан ажиллахыг

6326050278

чиглэл болгосон байна.

**Бусад асуудлын хэсэг**

Байгууллагын 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөгөөр нийт 3 зорилтын хүрээнд 40 арга хэмжээ хэрэгжүүлж ажиллан 94.6 хувьтай дүгнүүлсэн байна.

Тухайн аудитыг хийх явцад аудитын дүгнэлт, тайлантай холбогдуулан аудит гүйцэтгэж буй аудитор аливаа этгээдийн нөлөөлөл, мэдээллийн нууцлал, ёс зүйтэй холбоотой холбогдох хуулийн дагуу мэдэгдлүүдийг гарган баталгаажуулсан болно.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй. Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Д.БАТЦОГТ

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/Төгрөгөөр/

| Дансны код | Дансны нэр, төрөл | 1. Эхний үлдэгдэл | 2. Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| 1 | ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН | 334,433,382.37 | 382,466,444.26 |
| 31 | МӨНГӨН ХӨРӨНГӨ | 128,510,931.59 | 136,758,261.14 |
| 31200 | Банкинд байгаа бэлэн мөнгө | 128,510,931.59 | 136,758,261.14 |
| 31210 | Төгрөг | 128,510,931.59 | 136,758,261.14 |
| 31211 | Төрийн сангийн харилцах | 128,510,931.59 | 136,758,261.14 |
| 33 | АВЛАГА | 1,142,398.71 | 1,142,398.71 |
| 33500 | Бусад авлага | 1,142,398.71 | 1,142,398.71 |
| 33510 | Байгууллагаас авах авлага | 1,142,398.71 | 1,142,398.71 |
| 35 | БАРАА МАТЕРИАЛ | 204,780,052.07 | 244,565,784.41 |
| 35100 | Түүхий эд материал | 30,696,840 | 11,728,782 |
| 35110 | Тусгай зориулалттай материал | 30,281,340 | 11,198,282 |
| 35130 | Эм боох материал | 415,500 | 530,500 |
| 35300 | Бэлэн бүтээгдэхүүн | 996,000 | 996,000 |
| 35400 | Хангамжийн материал | 172,787,212.07 | 231,541,002.41 |
| 35410 | Бичиг хэргийн материал | 11,666,020.1 | 11,368,120.1 |
| 35420 | Аж ахуйн материал | 111,770,944.13 | 115,951,244.13 |
| 35450 | Барилгын засварын материал | 0.0 | 34,216,750 |
| 35460 | Хүнсний материал | 16,158,657 | 36,813,297.34 |
| 35470 | Бусад хангамжийн материал | 33,191,590.84 | 33,191,590.84 |
| 35600 | Мал амьтад | 300,000 | 300,000 |
| 2 | ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН | 2,568,720,475.05 | 2,615,169,028.4 |
| 39 | ҮНДСЭН ХӨРӨНГӨ | 2,568,720,475.05 | 2,615,169,028.4 |
| 39200 | Биет хөрөнгө | 2,407,189,782.36 | 2,465,640,739.43 |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 2,453,237,477.23 | 2,453,237,477.23 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | -257,292,664 | -314,156,623.36 |
| 39205 | Машин тоног төхөөрөмж(компьютер) | 301,910,036.24 | 449,900,091.24 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | -179,505,258.56 | -227,274,541.9 |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 163,167,935.97 | 194,752,415.97 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | -102,364,036.71 | -118,854,371.94 |
| 39214 | Бусад үндсэн хөрөнгө | 4,758,940 | 4,758,940 |
| 39217 | Ном | 23,277,352.19 | 23,277,352.19 |
| 39300 | Биет бус хөрөнгө | 161,530,692.69 | 149,528,288.97 |
| 39301 | Програм хангамж | 78,112,018 | 83,062,018 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | -2,923,325.31 | -19,875,729.03 |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 86,342,000 | 86,342,000 |

| | | | |
|---|---|---|---|
| 3 | НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН 3=1+2 | 2,903,153,857.42 | 2,997,635,472.66 |
| 4 | НИЙТ ӨР ТӨЛБӨР | 40,705,881 | 40,621,109 |
| 41 | БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР | 40,705,881 | 40,621,109 |
| 41300 | Өглөг | 40,705,881 | 40,621,109 |
| 41360 | Бусад өглөг | 40,705,881 | 40,621,109 |
| 41361 | Байгууллагад төлөх өглөг | 40,621,109 | 40,621,109 |
| 41362 | Хувь хүмүүст төлөх өглөг | 84,772 | 0.0 |
| 5 | ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН | 2,862,447,976.42 | 2,957,014,363.66 |
| 51 | Засгийн газрын хувь оролцоо | 2,862,447,976.42 | 2,957,014,363.66 |
| 51100 | Засгийн газрын оруулсан капитал | 1,003,170,165.12 | 1,003,170,165.12 |
| 511002 | Орон нутгийн төсвийн оруулсан хөрөнгө | 1,003,170,165.12 | 1,003,170,165.12 |
| 51200 | Хуримтлагдсан үр дүн | 1,561,161,792.28 | 1,655,728,179.52 |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | 1,585,323,321.96 | 1,561,161,792.28 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | -24,161,529.68 | 94,566,387.24 |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 298,116,019.02 | 298,116,019.02 |
| 6 | ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН 6=4+5 | 2,903,153,857.42 | 2,997,635,472.66 |

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/Төгрөгөөр/

| Дансны код | Дансны нэр, төрөл | 1. Өмнөх он | 2. Тайлант он |
|---|---|---|---|
| I | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН | 2,253,819,440 | 2,796,156,105 |
| 12 | ТАТВАРЫН БУС ОРЛОГО | 48,199,640 | 2,796,156,105 |
| 120 | Нийтлэг татварын бус орлого | 48,199,640 | 189,034,205 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 6,460,400 | 2,107,400 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 6,460,400 | 0 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 0.0 | 2,107,400 |
| 120017 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө | 16,739,900 | 152,710,055 |
| 120018 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал | 24,999,340 | 34,216,750 |
| 122 | Тусламжийн орлого | 0.0 | 2,607,121,900 |
| 1221 | Хандив тусламж /дотоод/ | 0.0 | 2,607,121,900 |
| 12211 | Харъяа төрийн сангаас төсвийн байгууллагад олгосон санхүүжилт, шилжүүлгийн орлого | 0.0 | 2,607,121,900 |
| 122111 | Урсгал санхүүжилтийн орлого\\ | 0.0 | 2,607,121,900 |
| 13 | ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО | 2,205,619,800 | 0.0 |
| 1310 | Улсын төвлөрсөн төсвөөс | 2,205,619,800 | 0.0 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 2,205,619,800 | 0.0 |

| | | | |
|---|---|---|---|
| II | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН | 2,277,980,969.68 | 2,701,589,717.76 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 2,277,980,969.68 | 2,701,589,717.76 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 2,204,669,987.28 | 2,585,528,502.7 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 1,718,113,440.29 | 1,991,409,452.63 |
| 210101 | Үндсэн цалин | 1,093,753,796.29 | 1,115,815,514.73 |
| 210102 | Нэмэгдэл | 589,679,819 | 701,810,158.21 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 0.0 | 56,705,000 |
| 210104 | Урамшуулал | 34,679,825 | 117,078,779.69 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 208,421,281.75 | 248,376,145.93 |
| 210201 | Тэтгэврийн даатгалын зардал | 141,336,521.9 | 169,403,379.35 |
| 210202 | Тэтгэмжийн даатгалын зардал | 16,762,456.85 | 19,763,641.16 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгалын зардал | 8,416,580.88 | 9,976,209.55 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгалын зардал | 8,381,024.88 | 9,894,734.63 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгалын зардал | 33,524,697.24 | 39,338,181.24 |
| 2105 | Нормативт зардал | 74,856,794.7 | 102,829,861.6 |
| 210502 | Хоол, хүнс | 74,856,794.7 | 102,829,861.6 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 9,089,100.95 | 29,365,026.89 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 9,089,100.95 | 29,365,026.89 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 194,189,369.59 | 213,548,015.65 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 62,512,504 | 61,713,834 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 12,848,340 | 13,758,200 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 118,828,525.59 | 138,075,981.65 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 73,310,982.4 | 116,061,215.06 |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 73,310,982.4 | 116,061,215.06 |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | 73,310,982.4 | 107,219,515.06 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 0.0 | 8,841,700 |
| III | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II) | -24,161,529.68 | 94,566,387.24 |
| VI | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(VII) | -24,161,529.68 | 94,566,387.24 |

## 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/Төгрөгөөр/

| Дансны код | Дансны нэр, төрөл | 1. Өмнөх он | 2. Тайлант он |
|---|---|---|---|
| I | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН | 2,212,164,972 | 2,609,229,300 |
| 12 | ТАТВАРЫН БУС ОРЛОГО | 6,545,172 | 2,609,229,300 |
| 120 | Нийтлэг татварын бус орлого | 6,545,172 | 2,107,400 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 6,460,400 | 2,107,400 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 6,460,400 | 2,107,400 |

| | | | |
|---|---|---|---|
| 120009 | Бусад орлого | 84,772 | 0 |
| 122 | Тусламжийн орлого | 0.0 | 2,607,121,900 |
| 1221 | Хандив тусламж /дотоод/ | 0.0 | 2,607,121,900 |
| 12211 | Харъяа төрийн сангаас төсвийн байгууллагад олгосон санхүүжилт, шилжүүлгийн орлого | 0.0 | 2,607,121,900 |
| 122111 | Урсгал санхүүжилтийн орлого\\ | 0.0 | 2,607,121,900 |
| 13 | ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО | 2,205,619,800 | 0.0 |
| 1310 | Улсын төвлөрсөн төсвөөс | 2,205,619,800 | 0.0 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 2,205,619,800 | 0.0 |
| II | НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН | 2,157,354,443.2 | 2,569,167,490.45 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 2,157,354,443.2 | 2,569,167,490.45 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 2,090,409,749.2 | 2,447,478,194.45 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 1,718,113,440.29 | 1,991,409,452.63 |
| 210101 | Үндсэн цалин | 1,093,753,796.29 | 1,115,815,514.73 |
| 210102 | Нэмэгдэл | 589,679,819 | 701,810,158.21 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 0.0 | 56,705,000 |
| 210104 | Урамшуулал | 34,679,825 | 117,078,779.69 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 209,563,680.46 | 248,376,145.93 |
| 210201 | Тэтгэврийн даатгалын зардал | 142,478,919.84 | 169,403,379.35 |
| 210202 | Тэтгэмжийн даатгалын зардал | 16,762,457.62 | 19,763,641.16 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгалын зардал | 8,416,580.88 | 9,976,209.55 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгалын зардал | 8,381,024.88 | 9,894,734.63 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгалын зардал | 33,524,697.24 | 39,338,181.24 |
| 2105 | Нормативт зардал | 78,886,564.5 | 117,856,421 |
| 210502 | Хоол, хүнс | 78,886,564.5 | 117,856,421 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 14,664,400.95 | 29,365,026.89 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 3,145,300 | 0.0 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 11,519,100.95 | 29,365,026.89 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 69,181,663 | 60,471,148 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 53,772,463 | 49,441,648 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 15,409,200 | 11,029,500 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 66,944,694 | 121,689,296 |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 66,944,694 | 121,689,296 |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | 66,944,694 | 112,847,596 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 0.0 | 8,841,700 |
| III | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II) | 54,810,528.8 | 40,061,809.55 |
| V | ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН | 72,478,209 | 31,814,480 |

| | | | |
|---|---|---|---|
| 22 | ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ | 72,478,209 | 31,814,480 |
| 2200 | Дотоод эх үүсвэрээр | 72,478,209 | 31,814,480 |
| 225106 | Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал | 72,478,209 | 31,814,480 |
| VI | ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V) | -72,478,209 | -31,814,480 |
| VIII | НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII) | -17,667,680.2 | 8,247,329.55 |
| 101 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | 146,178,611.79 | 128,510,931.59 |
| 20 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | 128,510,931.59 | 136,758,261.14 |
| 99 | Хамаарахгүй | 0.0 | 0.0 |

## 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

**/Төгрөгөөр/**

| № | Дансны нэр, төрөл | 1. Устгалын өмнөх | | | |
|---|---|---|---|---|---|
| | | 1.1 Засгийн газрын оруулсан капитал | 1.2 Дахин үнэлгээний нөөц | 1.3 Хуримтлагдсан үр дүн | 1.4 Засгийн газрын хувь оролцооны нийт дүн |
| 1 | 2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 1,003,170,165.12 | 298,116,019.02 | 1,585,323,321.96 | 2,886,609,506.1 |
| 3 | Дахин илэрхийлсэн үлдэгдэл | 1,003,170,165.12 | 298,116,019.02 | 1,585,323,321.96 | 2,886,609,506.1 |
| 9 | Тайлант үеийн үр дүн | 0.0 | 0.0 | -24,161,529.68 | -24,161,529.68 |
| 10 | 2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 1,003,170,165.12 | 298,116,019.02 | 1,561,161,792.28 | 2,862,447,976.42 |
| 11 | 2025 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл | 1,003,170,165.12 | 298,116,019.02 | 1,561,161,792.28 | 2,862,447,976.42 |
| 13 | Дахин илэрхийлсэн үлдэгдэл | 1,003,170,165.12 | 298,116,019.02 | 1,561,161,792.28 | 2,862,447,976.42 |
| 19 | Тайлант үеийн үр дүн | 0.0 | 0.0 | 94,566,387.24 | 94,566,387.24 |
| 20 | 2025 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл | 1,003,170,165.12 | 298,116,019.02 | 1,655,728,179.52 | 2,957,014,363.66 |

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

**/Төгрөгөөр/**

| Дансны код | Дансны нэр, төрөл | 1. Төлөвлөгөө | 2. Гүйцэтгэл |
|---|---|---|---|
| 1 | НИЙТ ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН | 2,661,144,600 | 2,609,229,300 |
| 12 | Татварын бус орлого | 2,661,144,600 | 2,609,229,300 |
| 120 | Нийтлэг татварын бус орлого | 2,107,400 | 2,107,400 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого /үндсэн/ | 427,400 | 2,107,400 |

| | | | |
|---|---|---|---|
| 120010 | Төсөв байгууллагын өөрийн орлого /туслах/ | 1,680,000 | 0 |
| 122 | Тусламжийн орлого | 2,659,037,200 | 2,607,121,900 |
| 122005 | Төсвөөс санхүүжих | 2,659,037,200 | 2,607,121,900 |
| II | НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН | 2,786,971,700 | 2,600,981,970.45 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 2,786,971,700 | 2,600,981,970.45 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 2,661,595,900 | 2,479,292,674.45 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 2,137,793,300 | 1,991,409,452.63 |
| 210101 | Үндсэн цалин | 1,298,060,500 | 1,115,815,514.73 |
| 210102 | Нэмэгдэл | 783,035,200 | 701,810,158.21 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 0.0 | 56,705,000 |
| 210104 | Урамшуулал | 56,697,600 | 117,078,779.69 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 267,224,400 | 248,376,145.93 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 181,712,500 | 169,403,379.35 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 21,377,900 | 19,763,641.16 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 10,689,000 | 9,976,209.55 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 10,689,000 | 9,894,734.63 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 42,756,000 | 39,338,181.24 |
| 2105 | Нормативт зардал | 123,217,900 | 117,856,421 |
| 210502 | Хоол, хүнс | 123,217,900 | 117,856,421 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 40,365,200 | 29,365,026.89 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 2,792,500 | 0.0 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 37,572,700 | 29,365,026.89 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 92,995,100 | 92,285,628 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 81,949,900 | 81,256,128 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 11,045,200 | 11,029,500 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 125,375,800 | 121,689,296 |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 125,375,800 | 121,689,296 |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | 116,534,100 | 112,847,596 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 8,841,700 | 8,841,700 |
| 8 | ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН НИЙТ ТЭНЦЭЛ | -125,827,100 | 8,247,329.55 |
| 9 | АЛДАГДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР | 125,827,100 | -8,247,329.55 |
| 7 | Харилцах болон хадгаламжийн дансны цэвэр өөрчлөлт | 125,827,100 | -8,247,329.55 |
| 4 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | 0.0 | 128,510,931.59 |
| 5 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | 0.0 | 136,758,261.14 |

## 3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 42,048.9 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 1,925.4 мянган төгрөгийн 2 төлбөрийн акт, 39,210.8 мянган төгрөгийн 3 албан шаардлага, 912.7 мянган төгрөгийн зөрчилд 3 зөвлөмж хүргүүлсэн байна.

### 3.1 Төлбөрийн акт

- *Илрүүлэлт:* Багш нарын баярын арга хэмжээний тэмцээн уралдаанд оролцсон Дуу хөгжмийн багш Т.Даваадоржид нэг сарын цалинтай тэнцэх хэмжээний 1 484.0 мянган төгрөгийн урамшууллыг буруу эрх зүйн үндэслэлээр үр дүнгийн урамшууллыг давхардуулан олгосон байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1.төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах, 41 дугаар зүйлийн 41.2.3-д "төсвийн гүйцэтгэлийг хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлж, тайлагнах" Засгийн 2019 оны газрын 5 дугаар тогтоолоор батлагдсан "Төрийн албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журам"-ын 2.2. "Төрийн албан хаагчид улирлын ажлын үр дүнгээр олгох мөнгөн урамшууллын дээд хэмжээ нь албан хаагчийн албан тушаалын сарын үндсэн цалингийн 50 хувиас хэтрэхгүй байна" гэсэн заалтуудыг хэрэгжүүлж ажиллаагүй байна.
- *Илрүүлэлт:* Хүнсний материалын орлого зарлагын гүйлгээг тухай бүрт нь хийдэггүй, явцын аудитаар биет тооллого хийхэд хүнсний материал 441.4 мянган төгрөгийн хүнсний материал дутагдалтай байгаа нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.2-т "төсвийн иж бүрэн, үнэн зөв байдлыг хангасан байх" 41 дугаар зүйлийн 41.2.7. "хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт тавих, хүрэх үр дүнг хангаж ажиллах" 5 дугаар зүйлийн 5.1.3."санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх" Нягтлан бодох бүртгэлийн 5 дугаар зүйлийн 5.1.4"үнэн зөв байх"; 5 дугаар зүйлийн 5.1.5."хэмжигдэхүйц байх" гэсэн заалтуудыг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

### 3.2 Албан шаардлага

- *Илрүүлэлт:* Бараа материалын дансны үлдэгдэлд биетээр байхгүй 300.0 мянган төгрөгийн мал амьтад бүртгэлтэй байгаа нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.2. "өсвийн иж бүрэн, үнэн зөв байдлыг хангасан байх", Нягтлан бодох бүртгэлийн 20 дугаар зүйлийн 20.2.6."эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах" гэсэн заалтууд зөрчигдөж байна.

- *Илрүүлэлт:* Тус сургуулийн захирал хөдөлмөр аюулгүй байдлын ажилтны албан тушаалыг 1 сар хавсран гүйцэтгэж 654.8 мянган төгрөгийн цалин авсан нь Хөдөлмөрийн аюулгүй байдлын тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.2."Ажил олгогч нь үйлдвэрлэл, үйлчилгээний онцлог, ажлын байрны эрсдэлийн түвшин, ажилтны тоог харгалзан хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн асуудал хариуцсан бүтэц болон ажилтан, зөвлөл ажиллуулна". 27 дугаар зүйлийн 27.4."Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн асуудал хариуцсан ажилтнаар инженер, техникийн болон эрүүл ахуйн боловсролтой, мэргэшсэн хүнийг ажиллуулна" гэсэн заалт зөрчигдсөн байна.

- *Илрүүлэлт:* Моби нет төхөөрөмжийг зээлээр худалдан авах гэрээг хийн худалдан авсан тушаал шийдвэр байхгүй, цахим дэлгүүрт байхгүй компаниас худалдан авалт хийж тухайн жилд төлөх төлбөрийг төлж 38 256.0 мянган төгрөгийн өглөгийн үлдэгдэлтэй байгаа нь Төрийн болон орон нутгийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 31.2.Энэ хуулийн 37.2.4-т "тодорхойлсон захиалагч ерөнхий гэрээ байгуулсан бараа, үйлчилгээг энэ хуульд өөрөөр заагаагүй бол цахим дэлгүүрээс худалдан авна" Төсвийн тухай хууль 6.6.2. "төсвийн захирагч нь төсвийн асуудлаа өөрийн харьяалагдах дээд шатны төсвийн захирагчаар дамжуулан шийдвэрлүүлдэг байх", 6.4.8. "төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх". заалтууд зарчигдсөн байна.

### 3.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дараалаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

***1. Зардлын данстай холбоотой асуудал***

***<u>Илрүүлэлт</u>:*** Групптэй ажилтны амралтын бодохдоо групптэй хүнд нэмж олгох хоногийг нэмж тооцоогүй 5 хоногийн амралтын мөнгийг ажилласан цалингаар бодож 510.6 мянган төгрөгийг дутуу бодож олгосон нь Хөдөлмөрийн тухай хуулийн 99 дүгээр зүйлийн 99.4-т "Хөгжлийн бэрхшээлтэй болон 18 насанд хүрээгүй ажилтны ээлжийн үндсэн амралтын хугацаа ажлын 20 өдөр байна" гэсэн заалтыг зөрчсөн байна.

***<u>Өгсөн зөвлөмж</u>*:** Цалин хөлсний тооцоолол хийхдээ холбогдох хууль тогтоомжийг судлах.

***2. Зардлын данстай холбоотой асуудал***

***<u>Илрүүлэлт</u>:*** Төрийн албан хаагчид олгох эмчилгээний зардлын 402.0 мянган төгрөгийн нөхөх төлбөрийг олгохдоо сугалааны дугаартай баримтаар олгосон нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7."Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно", 20 дугаар зүйлийн 20.1.4."хүчин төгөлдөр бус анхан шатны баримтаар, эсхүл анхан шатны баримтаар баталгаажаагүй ажил, гүйлгээг бүртгэхгүй байх"; Төрийн албан хаагчид нөхөн төлбөр олгох журмын 1.3. "Төрийн албан хаагчид нөхөх төлбөр олгоход шаардагдах хөрөнгийг тухайн байгууллага төсөвтөө тусгаж санхүүжүүлнэ". гэсэн заалтууд зөрчигдөж байна.

***<u>Өгсөн зөвлөмж</u>*:** Холбогдох хууль тогтоомжийг баримтлан ажиллах

***3. Үндсэн хөрөнгийн данстай холбоотой асуудал***

***<u>Илрүүлэлт</u>:*** Үндсэн хөрөнгийн дансанд элэгдлээрээ өртгөө бүрэн нөхсөн тэг үлдэгдэлтэй 114 435.3 мянган төгрөгийн анхны өртөгтэй 104 нэр төрлийн 746 ширхэг хөрөнгө бүртгэлтэй байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3."холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах",ТӨБЗГ-ын 2019 оны 271 дүгээр тогтоолын 7 дугаар зүйлийн 7.1-д “Төрийн өмчит хуулийн этгээд нь эзэмшилдээ байгаа илүүдэл эд хөрөнгө болон элэгдэл хорогдлын шимтгэлээр анхны үнийг нөхсөн, түүнчлэн нөхөөгүй боловч гэмтэж засаж сэлбээд өөр зориулалтаар ашиглаж болох эд хөрөнгийн ашиглалтын хугацаа болон үнийг шинэчлэн тогтоох саналыг бэлтгэн Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлж шийдвэрлүүлнэ.” гэсэн заалт зөрчигдөж байна.

***<u>Өгсөн зөвлөмж</u>*:** Холбогдох хууль тогтоомжийг баримтлан ажиллах

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5.Шалгагдагч этгээд болон холбогдох бусад албан тушаалтан нь энэ хуулийн 20.2-т заасан зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор төрийн аудитын байгууллагад ирүүлнэ гэж заасны дагуу аудитаар илэрсэн зөрчлийг арилгаж ажиллах ажлын төлөвлөгөөг боловсруулан 2025 оны 03 дугаар сарын 25-ны өдрийн дотор, зөвлөмжийн биелэлтийг 2025 оны 6 дүгээр сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

**Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл**

/мянган төгрөгөөр/

| | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | | Хариуцлага тооцуулах албан шаардлага | | Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | тоо | Тоо | Дүн |
| нэг сарын цалинтай тэнцэх хэмжээний 1 484.0 мянган төгрөгийн урамшууллыг буруу эрх зүйн үндэслэлээр | 1 | 1,484.0 | 1 | 1,484.0 | | | | | | | | |

| | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| үр дүнгийн урамшууллыг давхардуулан олгосон | | | | | | | | | | | | |
| хүнсний материал 441.4 мянган төгрөгийн хүнсний материал дутагдалтай | 1 | 441.4 | 1 | 441.4 | | | | | | | | |
| биетээр байхгүй 300.0 мянган төгрөгийн мал амьтад бүртгэлтэй | 1 | 300.0 | | | **1** | 300.0 | | | | | | |
| хөдөлмөр аюулгүй байдлын ажилтны албан тушаалыг 1 сар хавсран гүйцэтгэж 654.8 мянган төгрөгийн цалин авсан | 1 | 654.8 | | | **1** | 654.8 | | | | | | |
| 38 256.0 мянган төгрөгийн өглөгийн үлдэгдэлтэй | 1 | 38,256.0 | | | **1** | 38,256.0 | | | | | | |
| тэг үлдэгдэлтэй 114 435.3 мянган төгрөгийн анхны өртөгтэй 104 нэр төрлийн 746 ширхэг хөрөнгө бүртгэлтэй | 1 | - | | | | | 1 | - | | | | |
| 402.0 мянган төгрөгийн нөхөх төлбөрийг олгохдоо сугалааны дугаартай баримтаар олгосон | 1 | 402.0 | | | | | 1 | 402.0 | | | | |
| 5 хоногийн амралтын мөнгийг ажилласан цалингаар бодож 510.6 мянган төгрөгийг дутуу бодож олгосон | 1 | 510.7 | | | | | 1 | 510.7 | | | | |
| **Дүн** | **8** | **42,048.9** | **2** | **1,925.4** | **3** | **39,210.8** | **3** | **912.7** | | | | |